

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

THE HISTORY AND DEVELOPMENT OF FORENSIC SCIENCE IN FRANCE AND ITS SPECIALIZED DISCIPLINES

З.Сүлд

Шинжлэн магадлахуйн доктор

Z.SULD

Forensic science Ph.D

П.ЭНХМАА

Франц хэл судлаач,
Эрх зүйн магистрант

P.ENKHMAA

Bachelor of French studies,
master candidate of forensic science

Хураангуй: Энэхүү илтгэлд Шинжлэн магадлахуйн шинжлэх ухааны түүхэнд томоохон байр суурь эзлэх Франц Улсын шинжлэн магадлахуйн үүсэл хөгжлийн түүх болон тус улсын шинжлэн магадлахуйн үйл ажиллагааны онцлогийг тоймлон авч үзлээ.

Abstract: This abstract encapsulates key elements of France's forensic background, encompassing principal techniques, main institutions, their specialized, and the legal frameworks that underpin these practices.

Түлхүүр үг: Шинжлэн магадлахуйн шинжлэх ухаан, Бүгд Найрамдах Франц Улс, шүүх шинжилгээ, шинжлэн магадлахуйн лаборатори

Keywords: Forensic science, French Republic, legislation procedures, criminal analyses, forensic laboratories

Үндсэн хэсэг: Шинжлэн магадлахуйн шинжлэх ухаан эртний улбаатай ч дэлхий дахинд албан ёсоор XIX зуунаас XX зууны эхэн үед үүсч хөгжсөн гэж үздэг. ¹19 дүгээр зуунд Европ төдийгүй дэлхий дахинаа Шинжлэн магадлахуйн шинжлэх ухааны түүхэн хөгжилд онцгойлон тэмдэглэх, томоохон үйл явдал, нээлтүүд нь Франц улсын эрдэмтэн, судлаачтай салшгүй холбоотой хөгжсөн

¹ Эртний эх сурвалжид Хятадад МЭӨ V зууны эхэн үед тус улсын шүүгч Сүнзийн “Хир бургтаас ангижрахуй” номонд гэмт хэргийг илрүүлэхэд эд мөрийн баримтыг шалгаж, шинжлэх аргуудыг тодорхойлсон байдаг.

байдаг. Тухайлбал, Эдмунд Локард буюу “Францын Шерлок Холмс” юм. Франц улс төдийгүй дэлхийн бусад улс оронд шинжлэн магадлахуйн мэдлэгийн салбар үүсэн хөгжихөд Локардын дэвшүүлсэн онол, бүтээл нь үнэтэй хувь нэмэр оруулсан гэж үздэг. XIX зууны сүүл үед тус салбарыг үндэслэгч Эдмунд Локард 1910 онд Францын Лион хотод дэлхийн анхны шинжлэн магадлахуйн лабораторийг байгуулсан. “Лионы Шерлок Холмс” нэрээрээ олонд танигдсан Локард алдарт “Локардын харилцан үйлчлэлийн зарчим”-ыг томъёолсон бөгөөд *“харилцан үйлчлэл бүхэн ул мөрөө үлдээдэг”* гэдгийг баталсан. Энэхүү зарчим нь цаашид шинжлэн магадлахуйн салбарын онол, арга зүйн үндэс суурь болжээ. Тэрээр шинжлэн магадлахуйн шинжлэх ухаанд томоохон байр суурь эзлэх бөгөөд тодруулбал, үс болон өөдөс, ширхлэгийг буюу бичил мөрийг шинжлэхэд микроскоп ашиглах, хэргийн газраас ул мөрийн нотлох баримтыг системтэйгээр цуглуулах зэрэг криминалистикийн техник зүйд ихээхэн хувь нэмэр оруулсан. Эдмунд Локардыг орчин үеийн шинжлэн магадлахуйн ухааны үндэс суурийг тавьсан гэж салбарын эрдэмтэд нэгэн дуугаар хэлдэг.¹

Мөн Францын криминологич Альфонс Бертилон XIX зууны сүүл, XX зууны эхэн үед хүнийг тодорхойлох, таних, физик хэмжилтийн систем болох антропометрийн аргыг нэвтрүүлжээ. Тухайлбал, хүний биеийн хэсгүүд болох толгой, мөч зэргийг хэмжих аргыг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тодорхойлоход ашигласан.

1839 онд гэрэл зургийг нээсэн эрдэмтэд бол мөн л Франц улсын эрдэмтэд Ж.Ньепс, Л.Ж. Дагер нар юм. Германы эрдэмтэн Э.Стенгер гэрэл зураг анх бий болсон өдрөөс шүүх ажиллагаанд ашиглаж эхэлсэнийг нотолдог.² Энэ мэтчилэн Франц улсын эрдэмтэд шинжлэн магадлахуйн мэдлэгийн салбарт оруулсан нээлтүүд цөөнгүй бий.

Судалгаанаас үзэхэд Франц улсын шинжлэн магадлахуйн түүхэн хөгжлийн түвшинг бусад улстай харьцуулахад ижил байгаа нь харагдаж байна. Тухайлбал, Франц улсын шинжлэн магадлахуйн салбарын хөгжлийн үе буюу XX зууны эхэнд –Локардын удирдлаган дор Лион хотод байгуулсан лаборатори нь баллистик, токсикологи, баримт бичгийн шинжилгээ, серологи судлал зэрэг шинжлэн магадлахуйн төрөл бүрийн чиглэлээр өргөжин тэлж улмаар Дэлхийн II дайны дараа тус улсын шинжлэн магадлах ухаан нь техник, технологийн хөгжил дэвшилттэй зэрэгцээд хоёр шинжлэх ухааны уулзвар дээр үсрэнгүй хөгжих болсон. Үүний үр дүнд шинжлэн магадлахуйн лабораторид спектроскоп (spectroscopy), хроматограф (chromatography) болон бусад аналитик аргуудыг эрчимтэй нэвтрүүлж эхэлжээ.

¹ Michel Maze; Denise Stagnara; Louis-Paul Fischer., Article Researchgate [Dr. Edmond Locard (1877-1966), the Sherlock Holmes of Lyons], 2007.

² <https://mn.wikipedia.org/wik/>

Түүнчлэн, ХХ зууны сүүлчээр технологийн хурдацтай хөгжил, тэр дундаа молекул биологийн салбарт гарсан дэвшил нь шинжлэн магадлахуйн салбарт томоохон хувьсал гарч улмаар, ДНХ-ийн шинжилгээг өргөнөөр нэвтрүүлж эхэлсэн. Франц Улс хүний эрхийг хамгаалах асуудлыг нэгдүгээр тавьдаг ба мөрдөн шалгах үйл ажиллагаанд ДНХ-ийн шинжилгээг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлж улмаар Франц улсын Үндэсний Криминалистик ба Криминологийн Хүрээлэн (INCC) нь Үндэсний ДНХ-ийн мэдээллийн санг гэмт хэрэг илрүүлэхэд ашиглаж байна.¹

Дижитал технологийн хөгжлийг дагаад шинжлэн магадлахуйн салбар цахим шилжилт хийж эхэлсэн бөгөөд компьютерийн өгөгдөл, цахим харилцаа холбоо болон бусад дижитал нотлох баримтад шинжилгээ хийх нь кибер гэмт хэрэг болон бусад техник, технологитой холбоотой гэмт халдлага, гэмт хэргийг илрүүлэхэд ач холбогдол нь улам бүр нэмэгдсээр байна.

Бид судалгааны явцад Франц улсын шинжлэн магадлахуйн шинжлэх ухааны томоохон үйл явдал, нээлтийг он цагийн хэлхээнд оруулж түүхэн үечлэлд хамааруулахыг оролдлоо.

ФРАНЦ УЛСЫН ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙН ТҮҮХЭН ҮЕЧЛЭЛ	
Эртний үе XIX дүгээр зуун хүртэл	- Хувь хүнийг таних тодорхойлоход гарын мөрийн шинжилгээний арга хэрэгслийг нэвтрүүлэв. - Шинжлэн магадлахуйн баримт бичгийн хяналт шинжилгээний техникийн хөгжив.

¹ ДНХ-ийн шинжилгээг дэлхий дахинд анх 1984 онд Сэр Алек Жеффрис шүүх эмнэлгийн ДНХ-г боловсруулж, генетикийн кодын хэлбэлзлийг хувь хүмүүсийг таних, бие биенээ ялгахад ашиглаж болохыг нээсэн байна. ДНХ-ийн профилийн анхны хэрэглээг Жеффрис 1985 онд Английн Лайстерширийн жижиг хот болох Нарборо хотод үйлдэгдсэн аллагын хэргийг илрүүлэхэд ашиглаж байжээ. Линда Манн нэртэй 15 настай охин Карлтон Хейсийн сэтгэцийн эмнэлэгт хүчиндүүлж амь насаа алдсан байдаг бөгөөд цагдаагийн албан хаагчид сэжигтэн этгээдийг тогтоогоогүй боловч үрийн шингэний дээж авах боломжтой байлаа. 1986 онд 15 настай Даун Ашвортыг мөн ойролцоох Эндерби тосгонд хүчирхийлж, боомилон амь насыг хохироосон хэрэг үйлдэгдсэн бөгөөд шүүх эмнэлгийн дүгнэлтээс харахад алуурчид хоёулаа ижил цусны бүлэгтэй нь тогтоогдсон. Ричард Баклэнд нь Карлтон Хэйзийн сэтгэцийн эмнэлэгт ажилладаг, Даун Ашвортын амийг хөнөөсөн хэргийн ойролцоо харагдсан, хэргийн талаар олон нийтэд цацагдаагүй мэдээллийг мэдэж байсан тул сэжигтэн болжээ. Дараа нь тэр Дауны аллагыг хүлээн зөвшөөрсөн боловч Линдагийн аллага үйлдээгүй гэсэн байна. Үрийн шингэний дээжинд анализ хийхийн тулд Жефферисийг авчрав. Тэрбээр үрийн шингэний дээж болон Ричард Бакландын дээжтэй тохирохгүй байна гэж дүгнэсэн. Мөн Жефферис ДНХ-ийн профиль нь хоёр гэмт хэргийн газраас цуглуулан авсан үрийн шингэний дээж хоорондоо ижил болохыг батлав. Гэмт этгээдийг олохын тулд тус хотын 17-34 насны 4000 гаруй эрэгтэй хүний ДНХ-ийн дээжийг цуглуулжээ. Тэр бүгдийг гэмт хэргийн үрийн шингэний дээжтэй харьцуулсаны эцэст Колин Питчфоркийн ДНХ-ийн профиль нь тохирч 1987 онд баривчилсан байдаг.

Дунд үе XX зууны эхэн үе	• Цусны бүлэг болон серологи нь шүүх шинжилгээний хэрэгсэл болов. • Альфонс Бертильоны гэмт хэргийн танилт, физик хэмжилтийн систем болох антропометрийн системийг өргөнөөр ашиглаж эхлэв. • Шинжлэн магадлахуйн эмгэг судлал, хор судлал, баллистикийн аргыг ашиглах нь нэмэгдэв. • Хэргийн газрын тухай баримт бичгийн материалд гэрэл зургийг ашиглаж эхлэв.
Шинэ үе XX дүгээр зууны төгсгөлөөс XXI дүгээр зууны эхэн үе	• Хувь хүнийг таних хувьсгалт арга болох ДНХ-ийн профилийг (ДНХ гарын мөр) нэвтрүүлэв. • Полимеразын гинжин урвал (ПГУ) технологийн хөгжил нь ДНХ-ийн шинжилгээний үр ашгийг нэмэгдүүлэв. • Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаад ДНХ-ийн нотлох баримтыг ашиглах эрх зүйн зохицуулалт хэрэгжив. • ДНХ-ийн профилийг хадгалах үндэсний ДНХ-ийн мэдээллийн санг байгуулагдав. • Митохондрийн ДНХ-ийн шинжилгээ зэрэг дэвшилтэт шинжлэн магадлахуйн техникүүдийг нэгтгэв.
Нэн шинэ үе XXI дүгээр зууны эхэн үеэс	• Шинжлэн магадлахуйн шинжлэх ухаан болон компьютер, дижитал шинжилгээ зэрэг бусад салбаруудын хамтын ажиллагаа нэмэгдэв. • Шинжлэн магадлахуйн антропологи болон шавж судлал (entomology)-д дэвшил гарав. • Кибер гэмт хэргийн мөрдлөгөд дижитал шинжлэн магадлахуйн ач холбогдол нэмэгдэж байна.

Франц улсын шинжлэн магадлахуйн шинжлэх ухааны түүх нь тасралтгүй хувьсан хөгжиж байгаа бөгөөд түүхийн он цаг бүрт шинжээчийн дүгнэлтийн үнэн зөв, найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн шинэ техник, арга зүйг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсаар байна.¹

Орчин үед тус улсын шинжлэн магадлахуйн салбарын эрдэмтэн, судлаачид олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож, дэлхийн хэмжээнд шинжлэн магадлахуйн мэдлэг ур чадвар, хөгжил дэвшлийг дэлгэрүүлж, харилцан туршлага солилцож байгаа бөгөөд тус улсын шүүх шинжилгээний байгууллага нь бүтэц, тогтолцооны хувьд төрөлжин хөгжсөөр байна.

¹ www.justice.gouv.fr/documentation/ressources-du-ministere.

Франц Улсын шүүх шинжилгээний байгууллагууд



Франц Улсын шинжлэн магадлахуйн төв байгууллага нь Хууль зүйн яамны харьяа Үндэсний Криминалистик ба Криминологийн Институт (Institut National de Criminalistique et de Criminologie - INCC) бөгөөд судалгаа хийж, шүүх шинжилгээ хийх арга, техникийг хөгжүүлж, мөрдөн шалгах ажиллагаанд оролцох зэргээр шүүхийн байгууллагад шинжлэх ухаан, техникийн дэмжлэг үзүүлж ажилладаг.

Францын үндэсний жандармери (Gendarmerie nationale) нь БНФУ-ын “Дотоод хэрэг, хилийн чанад дахь бүс нутгийн яам”-ны харьяа бүхий хууль сахиулах байгууллага бөгөөд мөн Францын зэвсэгт хүчний яамны бүрэн эрхэд багтдаг. Үндэсний жандармери нь Францын хамгийн эртний байгууллагуудын нэг юм. Ялангуяа, хөдөө орон нутаг, хот орчмын газар нутаг болоод хилийн чанад дахь бүхий л нутаг дэвсгэрийг төлөөлж шүүх цагдаа, дэг журам сахиулах, цэргийн ажиллагаа явуулах чиглэлээр ажиллах үүрэгтэй аюулгүй байдлыг сахиулах хүчний байгууллага юм.¹

Үндэсний жандармери нь өөрийн шүүх шинжилгээний лабораториудтай бөгөөд шинжээчид ДНХ-ийн профиль, хор судлал, баллистик зэрэг олон төрлийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.

Үндэсний Жандармерийн Шүүхийн Төв (PJGN)-ийг 2011 онд байгуулсан бөгөөд шүүхийн чиглэлээр мэргэшсэн, Франц улсын бүх нутаг дэвсгэрийг хамарсан шүүхийн гол төв юм. Дээрх төв нь хүнд ноцтой хэрэг, шүүхийн хэрэг эсвэл удаан хугацааны мөрдөн шалгах ажиллагаа шаардлагатай хэргийн тохиолдолд Үндэсний жандармаас баг гарган томилдог бөгөөд тус төв нь 560 гаруй алба хаагчтай, үндсэн гурван бүтэц бүрэлдэхүүнтэй. Түүний нэг нь


¹ www.gendarmerie.interieur.gouv.fr/.

Үндэсний Жандармийн Гэмт хэргийн судалгааны хүрээлэн (IRCGN) бөгөөд тус хүрээлэн нь шүүх шинжилгээ хийх, гэмт хэргийн мөрдөн шалгах арга техникийн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй үндэсний жандармийн харьяа тусгай алба юм. Үүнд ДНХ, гарын мөр, баллистик, дижитал шүүх шинжилгээний зэрэг олон төрлийн шинжилгээний хэлтсүүд байрладаг¹. (Зураг 1)

Зураг 1. Үндэсний Жандармийн Гэмт хэргийн судалгааны хүрээлэн (IRCGN)



бүтэц, зохион байгуулалт



Эдгээр нэгжүүд нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Физик-химийн шүүх шинжилгээний хэлтэс (DCPC) нь физик-хими, баллистик, микроанализ, хүрээлэн буй орчин, гал, тэсрэх бодис, хор судлал зэрэг шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.
- Хүнийг танин тодорхойлох шүүх шинжилгээний хэлтэс (DCIH) нь шүүх эмнэлэг, антропологи ба гемаморфологи, ургамал, амьтан судлал, шүд судлал, гарын мөрийн зэрэг шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.
- Биологи, генетикийн шүүх шинжилгээний хэлтэс (DCBG) нь чиг үүргийн хувьд ижил генетикийн мэргэжилтнүүдээс бүрдэнэ.

¹ www.gendarmerie.interieur.gouv.fr/pjgn/institut-de-recherche-criminelle-de-la-gendarmerie-nationale.

- Инженерчлэл, дижитал шүүх шинжилгээний хэлтэс (DCIN) нь инженерчлэл, шинэ технологитой холбоотой шинжилгээг хариуцан хийдэг. Тухайлбал, мэдээллийн технологи, дүрс-ярианы дохио, баримт бичиг, тээврийн хэрэгсэл г.м

- Өгөгдөл боловсруулах үйлчилгээний алба нь индекс ба нотлох баримтын статистик боловсруулалтыг хариуцдаг. Битүүмжилсэн лавлагааны үйлчилгээ болон чанарын баталгаажуулалтын үйлчилгээг хянах, мөн хүрээлэнгийн удирдлагаас өгсөн чанарын бодлогыг сурталчлах ажлыг хариуцна .

Уг хүрээлэн нь ISO 17025 стандартын дагуу 120 гаруй туршилтын аргын магадлан итгэмжилсэн Европын шүүх шинжилгээний лабораторийн нэг бөгөөд тус лабораторт хийсэн шүүх шинжилгээг өндөр ач холбогдолтой нотолгооны эх сурвалж болгон үнэлж ажигладаг. БНФУ-ын хууль сахиулах байгууллага болох Цагдаагийн үндэсний байгууллага (Police Nationale) нь нийтийн хэв журмыг сахиулах, эрүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах үүрэгтэй. Тус улсын Дотоод хэрэг, хилийн чанад дахь бүс нутгийн яамны харьяа Цагдаагийн ерөнхий газар нь Цагдаагийн үндэсний байгууллагын газар, нэгжүүдийг удирдан чиглүүлэх үүрэгтэй.

Түүнчлэн, Үндэсний Жандармтай хавсарсан 3 газар нэгж бий .¹ Мөн, Үндэсний жандарматай зэрэгцээд Цагдаагийн үндэсний газар нь нотлох баримтыг шинжлэх зорилготой дэвшилтэт технологи бүхий *шүүх шинжилгээний лабораторитой*. Тухайлбал, Үндэсний шинжлэх ухааны цагдаагийн алба (Le service national de police scientifique (SNPS) нь Цагдаагийн үндэсний байгууллагын нэг хэсэг болохын хувьд хэргийн газар дээрх ажиглалт, дээж авах, лабораторийн дүн шинжилгээ хийх, баримт бичиг файл дээр харьцуулалт хийх гэсэн үндсэн гурван-чиг үүргийг гардан хэрэгжүүлдэг.

Мөн, Цагдаагийн үндэсний байгууллагын бүтцийн үндсэн нэгж болох Шүүх цагдаа нь шүүх шинжилгээний үйл ажиллагааг эрхэлдэг. Шүүх цагдаа нь эрүүгийн ноцтой гэмт хэргийг мөрдөн шалгах үүрэгтэй хууль сахиулах байгууллагын салбар бөгөөд үндсэн чиг үүргийн хүрээнд тус газрын криминалистикийн шинжээчид хэргийн газарт үзлэг хийх, нотлох баримт цуглуулах, бусад шинжилгээний байгууллагуудтай хамтран ажилладаг.

Бусад холбогдох байгууллага, лабораториуд нь шүүх шинжилгээний чиглэлээр хууль сахиулах байгууллагуудтай хамтарч, эсвэл бие даан ажиллаж, гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой.

Хууль эрх зүйн орчин ба стандарт

Франц улсын хувьд шүүх шинжилгээний тухай бие даасан хуульгүй бөгөөд Шүүх шинжилгээний байгууллагууд нь шинжээчийн дүгнэлт, нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх, ашиглах үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулдаг. Хууль, эрх зүйн зохицуулалт, стандартууд нь шүүх шинжилгээний найдварт

¹ www.police-nationale.interieur.gouv.fr/nous-decouvrir.

байдал, үнэн зөвийг баталгаажуулахад чиглэдэг бөгөөд тус улсад шинжлэн магадлах үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм журмаар зохицуулдаг хэдий ч шүүх шинжилгээтэй холбоотой тодорхой заалтыг удирдлага болгон эрүүгийн байцаан шийтгэх хуулийг дагаж мөрддөг. Тухайлбал, Франц улсын “Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль (Code de procédure penale)” нь хууль эрх зүйн үндсэн баримт бичиг болохын хувьд гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны дүрэм, журмыг тусгасан байдаг. Үүнд, нотлох баримтыг цуглуулах, ашиглахтай холбоотой тусгай заалтуудыг багтаасан байдаг.¹

Түүнчлэн, Франц улсын Засгийн газрын баримт бичгүүд болон стратегийн төлөвлөгөөнд шүүх шинжилгээний талаарх баримтлах төрийн бодлогыг тусгасан бөгөөд эдгээр нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд шүүх шинжилгээний нотлох баримтын чанар, баталгаатай, найдвартай байдлыг хангахад чиглэгддэг. Үүнээс гадна Франц улсын шинжлэн магадлах ухаанд чухал байр суурийг эзэлдэг байгууллага болох Үндэсний Криминалистик ба Криминологийн Институт (Institut National de Criminalistique et de Criminologie - INCC)-ийн байгууллагын талаар бид дээр өгүүлсэн.²

Франц улс бусад улсын нэгэн адил шүүх шинжилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад олон улсын стандарт, гэрээ хэлэлцээрийг дагаж мөрддөг. Үүнд, INTERPOL болон Европын Шинжлэн магадлахуйн холбоо (ENFSI) зэрэг байгууллагаас тогтоосон стандартууд багтана. Тус холбоо нь Европын улс орнуудын үйл ажиллагаа, чанарын баталгаажилтыг харилцан уялдуулах зорилгоор шүүх шинжилгээний удирдамж гаргаж шилдэг, тэргүүний туршлагуудыг бусад оронд нутагшуулах ажлыг хариуцдаг.

Дараагийн стандарт нь ISO юм. Олон улсын стандартчлалын байгууллага (ISO) нь бүх салбар, тэр дундаа шүүх шинжилгээний олон улсын стандартыг боловсруулдаг. Шүүх шинжилгээнд хамаарах ISO стандартууд нь чанарын менежмент, лабораторийн туршилт, ур чадварт тавигдах ерөнхий шаардлага зэрэг чиглэлүүдийг хамардаг.³

Франц Улсын шүүх шинжилгээний лабораториуд нь магадлан итгэмжлэлийн асуудалд онцгой анхаарал хандуулдаг. Уг хүрээнд эдгээр лаборатори нь үйл ажиллагаандаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дүрэм, журмыг дагаж мөрдөхийн зэрэгцээ шинжээчийн дүгнэлтийн нотолгооны ач холбогдлыг нэмэгдүүлэхийн тулд шинжилгээний дэвшилтэд арга зүйг боловсруулж, практикт нэвтрүүлэхийг эрхэмлэдэг.

Туршилт, тохируулгын лабораториудад ISO/IEC 17025 стандартыг түгээмэл хэрэглэдэг бөгөөд шүүх шинжилгээний чухал зорилтын нэг болох чанарын баталгаагаар дамжуулан шинжээчийн дүгнэлтийн үнэн зөв, найдвартай байдлыг хангахад чиглэсэн дүрэм, журмыг баталж, мөрддөг.

Дүгнэлт

¹ www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006071154/.

² www.incc.fgov.be/qualite-accreditation.

³ БНФУ-ын Хууль зүйн яамны албан ёсны цахим хуудас. Холбоос: www.justice.gouv.fr/justice-france/justice-penale.

Олон улсад шинжлэн магадлах ухааны түүхэн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан нээлтүүд нь Франц улсын эрдэмтэн, судлаачидтай салшгүй холбоотой.

Шинжлэн магадлах ухааны хөгжлийг XIX зууны сүүл үед Францын эрдэмтэн Эдмунд Локард шинэ шатанд гаргасан бөгөөд түүний харилцан үйлчлэлийн зарчим нь шинжлэн магадлахуйн салбарын онол, арга зүйг шинэ шатанд гаргахад чухал үүргийг гүйцэтгэжээ.

Франц Улсын шинжлэн магадлах ухааны үүсэл хөгжлийн түүхийн үечлэлийг тоймлон авч үзвэл, энэхүү үйл явц түүхийн он цагийн мөчлөг бүрт тасралтгүй хувьсан өөрчлөгдсөөр байсан хэдий ч, өөрийн өвөрмөц шинж чанарыг тууштай хадгалж, байнга хөгжиж дэвшсээр ирсэн бөгөөд шүүх шинжилгээ нь нийгэмд шударга ёсыг тогтооход чухал үүргийг гүйцэтгэсээр ирсэн гол салбарын нэг болохыг гэрчилж байна.

Иймд дэлхийн тэргүүлэгч орнуудын шинжлэн магадлах ухааны үүсэл хөгжлийн түүх болон цаашдын хөгжлийн чиг хандлагыг хэрхэн тодорхойлсоныг тоймлон судалж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр энэ чиглэлд хуримтлуулсан тэргүүн туршлагыг өөрийн орны шүүх шинжилгээний салбарт үр дүнтэй нэвтрүүлэх оновчтой арга замыг эрэлхийлэх, цаашлаад тус салбарын үйл ажиллагаа, байгууллагын бүтэц, тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэхэд чухал ач холбогдолтой гэж дүгнэж болохоор байна.

Ашигласан эх сурвалж

Ном, бүтээл:

1. Colonel Patrick Tournon., Le modèle forensique de l'Institut de Recherche Criminelle de la Gendarmerie Nationale (IRCGN), Page 29, Revue francophone des laboratoires - février 2017 - N°489, FRANCE
2. Michel Maze; Denise Stagnara; Louis-Paul Fischer., Article Researchgate [Dr. Edmond Locard (1877-1966), the Sherlock Holmes of Lyons], 2007

Цахим эх сурвалж:

1. Үндэсний Жандармерийн Шүүхийн төвийн албан ёсны цахим хуудас. Холбоос: www.gendarmerie.interieur.gouv.fr/pjgn/institut-de-recherche-criminelle-de-la-gendarmerie-nationale
2. БНФУ-ын Цагдаагийн үндэсний байгууллага (Police nationale) -ын албан ёсны цахим хуудас. Холбоос: www.police-nationale.interieur.gouv.fr/nous-decouvrir
3. Цахим эх сурвалж: Шүүх шинжилгээ - Криминалистик. Холбоос: www.criminalisticmn.blogspot.com
4. БНФУ-ын Хууль зүйн яамны албан ёсны цахим хуудас. Холбоос: www.justice.gouv.fr/justice-france/justice-penale
5. Францын Улсын Үндэсний Криминалистик ба Криминологийн Институтын цахим хуудас. Холбоос: www.incc.fgov.be/qualite-accréditation